

## ӨНӨӨГИЙН МОНГОЛ ХҮНИЙ ҮНЭЛЭМЖИЙН ЗАРИМ ОНЦЛОГ

Г. Буянтогтох\*

Хүний хэрэгцээ, ажил үйл, юм үзэгдлийг сэрж мэдрэх арга маш олон байхын дээр сэтгэлгээний хэв маяг, танин мэдэх хэмжээ, ертөнцийг үзэх үзэл, аливаад хандах хандлага ч харилцан адилгүй учраас ижилхэн мөн чанартай юмыг өөр өөр үнэлэмжийн хэмжүүрээр үнэлж дүгнэх нь байдаг. Тийм учраас ижилхэн нэг юмыг зарим хүн маш үнэтэй, чанартай, сайн сайхан гэж байхад зарим нь сөргөөр үзэх нь бий. Үнэлэмж нийт хүн төрөлхтний болон тодорхой анги, бүлэг, хувь хүний онцлог, байгаль орчин, нийгмийн байдал зэргээс хамааран өөр өөр байж болох харьцангуй шинжтэй ойлголт бөгөөд харилцааны хэрэглүүр - хэлний нэгжээр дамжин илрэх хэсгийг нь баймжийн ай хэмээдэг.

Хэлшинжлэлийн ухаанд баймжийн айн онолын үндэслэлийг анх “Өгүүлбэр бүхэн өөрийнх нь хамгийн гол шинж чанар болох баймж утгатай байдаг. Тэрхүү баймж утга нь бодит байдалтай харилцах харилцааг заадаг” (Виноградов. 1950.х-41)<sup>1</sup> хэмээн гаргасан бөгөөд баймжийн айн агуулга, утгазүйн багтаамжийг логик – хэлзүй, үүрэг – утгазүйн болон харилцааны талаас судлан шинжилж ирсэн байна (Мөнх -Амгалан. 1997. х-63)<sup>2</sup>.

Товчдоо бол баймжийн ай гэдэг өгүүлэгч эзэн биеэс тухайн бодит байдалд хандах хандлага; юм, үзэгдэлтэй харилцах харилцаа болон уг өгүүлэмжийн агуулгаар илэрч байгаа үнэлэмжийг илэрхийлдэг үүрэг – утгазүйн ай юм.

Тэгвэл үнэлэмж гэж юуг хэлдэг вэ ? Гүн ухааны ном зохиолд “Үнэлэмж гэдэг бол бидний бүх үйлдлийг утга учиртай болгодог, юуг буян, сайн юм, сайхан юм гэж үзэх төдийгүй зорилго болгон эрхэмлэж, түүнийхээ төлөө тэмцдэг, юуг нүгэл, муу юм, муухай юм гэж жигшдэг үйлдлийн утга учир юм. Үнэлэмж бол хүн, улс, үндэстний оюуны гень гэж хэлж болох юм” (Баатартогтох. 2007. х – 25)<sup>3</sup> гэх юм уу “... үнэлэмж бол субъектээс аль нэг хэрэгцээгээ хангах үүднээс тухайн объектийг хүсэх, үл хүсэх утга

\* МУИС-ийн МХСС-ийн Хэл шинжлэлийн тэнхим

<sup>1</sup> В.В.Виноградов. *О категории модальности и модальных словах в русском языке*. “Труды института русского языка”.М-Л. 1950

<sup>2</sup> Ю.Мөнх-Амгалан. *Орчин цагийн монгол хэлний баймжийн айн төвийн тогтолцоо*. МУИС. МСДС.ЭШБ.УБ. 1997. №9 (126)

<sup>3</sup> Ц.Баатартогтох. *Монгол хүний үнэлэмжийн байдал*. “Соёл судлаач багш нарын үндэсний Ү семинарын материал”УБ. 2007

бүхий үнэлгээ мөн” (Дорждагва. 2005. х- 40)<sup>4</sup>; өөрөөр хэлбэл, үнэлэмж бие хүний оюуны ухамсарт үйл ажиллагаагаар бий болсон субъектив үйлдэл, тэдний хүсэхүй хийгээд үл хүсэхүйн утгыг илэрхийлэх үнэлгээ юм(Одонтуяа. 2004. х-29)<sup>5</sup>. хүний өдөр тутмын үйл ажиллагаа үнэлэмжтэй салшгүй холбоотой; үнэлэмж гэдэг ямар нэг юмын шинж биш, харин мөн чанар учраас аливаа объектийн ахуйн нөхцөл болж чаддаг; үнэлэмжийг субъектийнх нь хүрээний үүднээс хувь хүний, бүлгийн, айлын, анги давхаргын, үндэстний, тухайн нийгмийн, хүн төрөлхтний гэж ангилж болохын дээр агуулгаар нь материалаг ба оюуны, үйл ажиллагааны, харилцааны гэх мэтээр тодорхойлж ирсэн байна.

Хүний бие, хэл, сэтгэлийн үйл дотор үнэлэмжээс ангид орших нь нэг ч үгүй учраас үнэлэмж маш олон бөгөөд товчоолон хэлбэл,

1. Нэг объект субъектээсээ хамааран өөр өөр ялгаатай үнэлэмжтэй байдаг. Угтаа нэг үзэгдэл, үйл явц, эд юмыг үнэлэмжийн хүрээнд субъект бүр өөр өөрөөр үнэлдэг. Нэг субъектийн хувьд эерэг үнэлэмж нөгөө субъектийн хувьд үнэлэмж биш юм уу, сөрөг үнэлэмж болж байх нь хүн төрөлхтний хувьд түгээмэл үзэгдлийн нэг юм.

2. Объект хэвээр байхад үнэлэмж өөр болсон байдаг. Тодруулбал, тухайн субъектийн хувьд үнэлэмжийн объект болж байсан зүйл үнэлэмжийн объект биш болох, сөрөг үнэлэмжийн объект болох гэх мэт.

3. Хамгийн их эрхэм дээд үнэлэмжийг эгэл юмаар илэрхийлж болдог бөгөөд сүсэг бишрэлийн үнэлэмжийн үүднээс алтан бурхан илүү үнэлэмжтэй, шавар бурхан бага үнэлэмжтэй гэж байхгүй, эдгээр үнэлэмж бүгд адил байна.

Аливаа ард түмний үнэлэмж тухайн үндэстний соёлын өв, сэтгэлгээгээр дамжин илэрнэ. Сэтгэлгээ нь тэрхүү ард түмний үнэлэмжийн бодит илэрхийлэл болдог бөгөөд үнэлэмж үндэстэн бүрт утга учир, ач холбогдлоороо өөр өөр байдаг. Тухайн ард түмний оюун сэтгэлгээний мөн чанар, онцлог шинжийг танихад үнэлэмжийн судалгаа ихээхэн ач холбогдолтой байдаг байна(Баатартогтох. 2000. х-29)<sup>6</sup>.

XX зууны сүүл үеэс нэн хүчтэй болж, зогсолтгүй урагшилсаар, өнөөгийн энэ өдрүүдэд Дэлхий нийтийг хамраад, үндэстэн угсаатан бүхэнд орших, эс оршихыг тулгаад байгаа “Даяарчлал – даяаршлын эринд . . . монгол хэл, соёлоо монголчууд бид л эс хэрэгсэн авч үлдвэл, бид л эс хайрлан хамгаалбал өөр хэн бугай ч бидний өмнөөс энэ өв хөрөнгийг хайрлан хямгадахгүй, авч хэрэглэхгүй” (Дулам.2005. х-62)<sup>7</sup>. Монголчууд бид өөрийн өв соёлыг сайтар судлан эзэмшиж, түүгээр зэвсэглэж байж даяаршлын эринд оршин тогтноно. Үүнд, өв соёл олон талтай бөгөөд тэдгээрээс өнөөгийн Монголын нийгмийн хөгжилд тулгараад байгаа зангилаа асуудлыг судалж, оновчтой шийдвэрлэх арга зам хайж олох нь амин чухал зорилт юм. Тийм асуудлын тоонд тухайн ард түмний газар зүйн байрлал, цаг агаар, аж ахуйн үйл ажиллагаа, сэтгэлгээний онцлог, хэл соёл, ёс заншил, ертөнцийг үзэх үзэл, үндэсний ухамсар, амьдралын хэв шинжээс хамаарч, илрэх хэлбэр нь харилцан адилгүй байдаг онцлогтой үнэлэмж багтана.

Монгол хүний үнэлэмжийн судалгааны түүх 1990 оноос хойшхи хэдэн жилийг л хамарч байгаа бөгөөд энэ хугацаанд монгол хүний үнэлэмжийн талаар “Нийгмийн ардчилсан үнэлэмжийн тогтолцоо” (Чулуунбаатар. 1998), “Үнэлэмж бол шийдвэрт

<sup>4</sup> Т.Дорждагва. Соёлын философи (түүхэн товчоон) УБ. 2002

<sup>5</sup> Л.Одонтуяа, Монгол зүйр цэцэн үгэнд, үнэлэмж илрэх онцлог. (Докторын Ph.D.) зэрэг горилох нэг сэдэвт бүтээл. УБ. 2004

<sup>6</sup> Ц.Баатартогтох. Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал. Дисс. УБ.2000

<sup>7</sup> С.Дулам. Монгол хэл соёлыг минь мохоох гээд байна уу даа?. “Монгол хэл бичиг.1.2005”

нөлөөлөгч хүчин зүйл мөн” (Баатартогтох. 1998), “Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал” (Баатартогтох. 2000), “Монгол зүйр цэцэн үгэнд үнэлэмж илрэх онцлог” (Одонтуяа. 2004), “Монгол болон америкчуудын ажилд хандах хандлага, үнэлэмж” (Нарантуяа. 2005), “Монгол хүний үнэлэмжийн байдал” (Баатартогтох. 2007) гэх мэт судалгааны бүтээл гарчээ.

Монголын ард түмэн Их гүрэн мөхсөнөөс хойшхи зургаан зуу гаруй жилийн дотор эхлээд Манжийн эзэнт гүрний боол болсон, дараа нь Зөвлөлтийн хийрхлийн коммунист суртлын дарангуйлалд орсон, сүүлийн 20 гаруй жилд социализмаас зах зээлийн нийгэм нэртэй посткапитализмд шилжиж эхэлсэн бөгөөд энэ бүхэн монгол хүний үнэлэмжид нэн хүчтэй нөлөөлж, *“Монгол соёл, үнэлэмж гэж байдаг бол . . . элдэв янзын эрээн бараан, алаг цоог, хоорондоо уялдаа холбоогүй, заримдаа эмх замбараагүй механик холимгоор дүүрсэн байна гэж зүйрлэн хэлж болох юм. Энэ холимгийг уламжлалын жаахан үр, социалист уламжлал, өнөөгийн шинэ зах зээлийн нийгмийн үнэлэмжийн бас нэг үр, гаднын соёл, шашны үнэлэмжийн зориудын ба зориудын бус нөлөөлөл, глобалчлалын нөлөө зэрэг зүйл бүрдүүлж байна. Монгол зүйрлэлээр бол үхрийн бөөр шиг юм. Гэхдээ үхрийн бөөр шиг нэгдсэн функцтэй байж чадахгүй учраас уутанд хийсэн эвэр шиг гэвэл илүү онох байх. . . Үнэлэмж төр засгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой. Нийгмийн үнэлэмжтэй зөрсөн аливаа бодлого шийдвэр хэрэгжих боломжоор хомс болдог төдийгүй зөрчил зөрөлдөөний эх үүсвэр, сурвалж . . .”* (Баатартогтох. 2007. х-25 - 27)<sup>8</sup> болдог байна.

Ийм нөхцөл байдал дунд монгол хүний амин язгуур үнэлэмж буюу оршихуйн үнэлэмж урьд өмнө үзэгдэж дуулдаагүй хурдан бөгөөд иж байдлаар бууран доройтож байна. Үүнд,

- а. Амь бие амар төвшин оршихуйн үндэс – Эх нутаг, газар шороогоо,
- б. Амин тэжээл элбэг арвин оршихуйн үндэс - Мал сүргээ,
- в. Ухаан билиг тэгш дүүрэн оршихуйн үндэс - Эх хэл, үндэсний бичгээ
- г. Сэтгэл санаа амгалан ариун оршихуйн үндэс - Бурханы шашнаа,
- д. Хүч чадал төгс бадрангуй оршихуйн үндэс - Эв нэгдлээ,
- е. Эх орон ашид мөнх мандан бадрахын үндэс - Төр, засгаа эрхэмлэн дээдлэх үнэлэмж 1990 оны нийгмийн хувьсгалаас хойш жилээс жилд буурсаар ноцтой асуудал болоод байна. Тухайлбал, харийнхны ашиг сонирхол, бодлого, зорилгыг нарийн шинжилсэн тооцоо, судалгаагүйгээр баялгаа эзэмшүүлж эхэлснээр газар нутаг, байгаль орчин хэрхэн сэхэж сэргэшгүйгээр эвдрэн сүйдэж, түүний улмаас малын өвс бэлчээр, ус унд яаж хомстож хумигдаж буй, харийн шашин соёл хэрхэн түрэмгийлж байгаа, улстөрийн нам, бүлэг яаж сөргөлдөж, хэрхэн эв эвдэж байгаа, сул дорой төр засаг улс орныг удирдан жолоодож чадахгүй хэрхэн доройтуулж байгаа гэх мэтээр энэ тухайд олныг өгүүлж болно.

Гэвч, энд бүгдийг тоочих боломжгүй тул ухаан билиг тэгш дүүрэн оршихуйн үндэс буюу монгол хэл, бичгийн үнэлэмжтэй холбоотой зарим юмыг авч үзье.

Манай ард түмэн түүхэндээ арав гаруй бичиг үсэг хэрэглэсэн бөгөөд тэдгээрийн дотр оос монгол бичиг зуунаас зуунд ард түмнээ өртөөлүүлэн тээж авчирсан, олон нутгийн монголчуудыг оюун санаа, ухаан билгийн хувьд нэгтгэхийн хамтаар аялгуу

<sup>8</sup>) Ц.Баатартогтох. *Монгол хүний үнэлэмжийн байдал*. “Соёл судлаач багш нарын үндэсний Ү семинарын материал”УБ. 2007

бүрийн оршин амьдарч хөгжиж цэцэглэх нөхцөлийг бүрдүүлж, монгол үндэстний сэтгэлгээний амин сүнс, оршихуйн нэг үндэс болж байсан учраас харийнхан энэ бичгийг Монголын нийгмийн амьдралаас шахан зайлуулж, өөрийнхөө бичгийг албадан хэрэглүүлсэн билээ<sup>9</sup>.

Тэр үе буюу ХХ зууны 40 - өөд он гэхэд Монгол орон тухайн цагийн ЗХУ - ын дагуул хараат болж хувирсан бөгөөд ингэснээр Төрийн үндэсний болон эх хэлний бодлого бүрэн алдагдаж эхэлсэн байна. Монголын төр засаг харийнхныг өөрийн ард түмний дээр тавьж, харь хэлний буюу орос хэл, орос бичиг үсгийн бодлого эрчимтэй явуулах болсноор монгол үндэстний өөрийн үнэлэмж, хэл, соёл, оршихуйн үндсээ эрхэмлэх сэтгэлгээ ихээхэн эвдрэн сүйдэх замд эргэлт буцалтгүй орж, 60 – аад жил өнгөрөхөд монгол аж амьдрал, ёс заншил, ахуй байдал харийн аж төрөх ёс, соёлын түрэмгийлэлд ялагдан автсан бөгөөд өнөөгийн байдлаар монгол хэл зөвхөн орос төдийгүй англи, хятад, япон, солонгос гэх мэт гадаадын олон хэлний түрэмгийлэл дунд цаг мөчтэй уралдан эвдэрч, “Хэдэн үеэ бүрэлгэх хэлний гамишг”<sup>10</sup> улам лавшран нүүрлэсээр байна.

Монгол Улсын Засгийн газар хуучин ЗХУ – ын үед орос хэлэнд нийтээр албадан сургаж, орос сургууль байгуулж, Зөвлөлтийн Боловсролын тогтолцоог хуулан дуурайж байсан шиг, англи хэлийг албадан сургаж, англи сургууль байгуулж, Кембрижийн сургалтын агуулга, хөтөлбөрийг ихээхэн сурталчлан тулгаж байгаагийн улмаас монгол үндэстний болон эх хэлний үнэлэмж маш хурдан буурч, бараг байхгүй болоод байгаа бөгөөд тэдний орыг англи зэрэг гадаад хэлийг чухалчлах, харийг дээдлэх үнэлэмж эзэлж, тэр нь эргээд монгол хэл, сэтгэлгээг үлэмжхэн эвдэж байна.

Монгол хэлний нэрлэх ёсыг бүдүүлгээр зөрчсөн **мөнгө олголт хийж эхлэх, нэрсийн жагсаалтад нэрээ бүртгүүлэлт хийх, нэрсийн жагсаалтаас нэрээ хасалт хийлгэх, өвөлжилтийн байдал хүндрэлтэй байна, газар хөдлөлт болох, ярилцлага хийх, хүндрэлтэй байдал тохиолдох** гэх мэт өч төчнөөн буруу хэлбэрт үг хэллэг болон түүнтэй төстэй бусад гаж хэллэг үүсээд байгаа бөгөөд ийм үг хэллэгийг “... олон монгол хүн, ялангуяа залуучууд хэвийн мэт ухаарах болжээ” (Шагдарсүрэн. 2007. х - 25)<sup>11</sup>. Дээр жишээ болгосон - **лт + үйл үг** бүтэцтэй хэдэн холбоо үгэлбэр, түүнтэй төстэй бусад гаж хэлбэр монгол болон европ хэлний нэрлэх ёсны ялгааг эс мэдсэнээс үүсчээ. Тодруулбал, “Монгол хэл үгсийг холбохдоо нэрээр холбохоос үйлээр холбох нь илүү... Монгол хэлний үйлээр холбодог хандлагыг анхаарч, нэрийг нь үйл болгож орчуулбал... монгол үгэлбэр болно. Зарим холбоо үгийн голлосон нэр үгийг үйл үг болгож хэлбэл илүү авсаар хэмнэлттэй болно... нэр үгээр бүтсэн нэр томъёог улам олишуулбал бичиг зохиолд нэр үг улам олишрч, үйл үг улам цөөрөх болно. Гэтэл үйл үг үгийн сангийн чухал хэсэг болохоос гадна өгүүлбэрзүйд үйл үг зохион байгуулах төв нь болно” (Лувсанвандан. 2005. х - 240 - 241)<sup>12</sup>.

Монгол хэлэнд - **лт** дагавраар бүтсэн нэр үг болон - **лт + үйл үг** бүтэцтэй холбоо үгэлбэр элбэгшсэнээр нэрлэх ёс ноцтой гажуудаж, нэг юм, үзэгдлийг жинхэнэ, жинхэнэ бусыг хослуулан, газар хөдлөх, газар хөдлөлт болох гэх мэтээр нэрлэн харилцах болоод

<sup>9</sup> БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл. I дэвтэр. УБ. 1941

<sup>10</sup> Ц. Базаррагчаа. Хэдэн үеэ бүрэлгэх хэлний гамишг. “МСС. ЭШБ. УБ. 1999

<sup>11</sup> Ц. Шагдарсүрэн. Эх хэлээ эвдэхгүй юм сан... УБ. 2007

<sup>12</sup> Ш. Лувсанвандан. Хэл, харьцаа, тэмдэг. УБ. 2005

байгаа бөгөөд энэ мэт үзэгдлийн хор хөнөөлийг таслан зогсоож, монгол хэлний үнэлэмжийг дээшлүүлэхийн тулд юуны өмнө Монгол төрийн эх хэлний бодлогыг жинхэнэ ёсоор тууштай явуулах нь чухал байна. Түүнчлэн, монгол болон гадаад хэлний мэргэжилтэн, орчуулагч, дуун хөрвүүлэгчийн эх хэлний боловсролыг чанарын дээд шатанд нэн даруй хүргэх хэрэгтэй юм. Эс тэгвэл, харь хэлнээс өдөр шөнөгүй махчилан орчуулсан, орчуулж буйн уршгаар монгол хэлэнд орж ирсэн гаж хэллэг, буруу нэр жинхэнэ монгол нэрийг шахан гаргаж орыг нь эзлэн, монгол хэл, сэтгэлгээг мохоон мохоосоор эцэст мөхөөж салахаар шинжтэй болоод байгаа бөгөөд эн тэргүүнд доорхи мэт үг, хэллэгийг яаралтай залруулж, зөв хэрэглэх явдал нэн чухал шаардлага болон тулгараад байна. Үүнд,

а. -ЛТ төгсгөлтэй болон ЛТ + ТУСЛАХ ҮЙЛ ҮГ бүтэцтэй үг, хэллэгийг *мөнгө олголт хийж эхлэх* – мөнгө олгож эхлэх, *нэрсийн жагсаалтад нэрээ бүртгүүлэлт хийх* – нэрээ бичүүлэх, *нэрсийн жагсаалтаас нэрээ хасалт хийлгэх* – нэрээ хасуулах, *өвөлжилтийн байдал хүндрэлтэй байна* - өвөлжөө зутруу байна, *газар хөдлөлт болох* - газар хөдлөх, *ярилцлага хийх* - ярилцах, *хүндрэлтэй байдал тохиолдох* - бэрхшээл тохиолдох, *цэргийн сургуулилт эхлэх* – цэргийн сургууль эхлэх, *газар олголт хийх* – газар олгох, *сэг зэм булалт хийлгэх* – сэг зэм булуулах, *нохой агналт хийх* – нохой агнах, *сонголт хийх* – сонгох, *гүний усны шумбалт хийх* – усанд гүн шумбах, *ойжуулалт хийх* – ойжуулах, *бараанд хүргэлт хийх* – барааг хүргэж өгөх, *гадаа хүйтрэлттэй байна* – гадаа хүйтэн байна, гадаа хүйтэрч байна, *өвөлжилт* - өвөлжөө, *газар хөдлөлт* – газар хөдлөх, *зохицуулалт* – зохицуулах, *түлхүүрдэлт* – түлхүүрдэх, *борлуулалт* – борлуулах, *бүртгүүлэлт* – бүртгүүлэх, *ажиглалт* – ажиглах, *цаг ашиглалт* – цаг ашиглах, *зохион байгуулалт* – зохион байгуулах, *айлчлалт* – айлчлах гэх мэтээр цагт нэрийн аль нэг нөхцөл болон бусад зохистой дагавар, нөхцөлөөр төгсгөн хэлбэржүүлж хэрэглэвэл монгол сэтгэлгээ, хэл найруулгад туйлын нийцтэй зохистой болж, монгол хэл эвдрэн мөхөхөөс хамгаалж чадна.

б. Орос хэлний високий(*высокая, высокое, высокие*) гэдэг үгийг хуулан орчуулж хэрэглэснээр үүсч, англи хэлний махчилсан орчуулгаар сэдрэн даамжирсан өндөр гэдэг тодотгол бүхий хэллэг монгол хэл, сэтгэлгээнд ихээхэн хор хохирол учруулж байгаа бөгөөд тэдгээрийг дахин нягталж, өндөр хэмээх тодотгол бүрийг зохистой монгол үгээр солин хэрэглэж сурах шаардлагатай байна.

в. Гадаад хэлнээс хуулан орчуулж үүсгэсэн Ажиллагаа явуулах гэдэг холбоо үгийг доорхи байдлаар ахин монголчлох хэрэгтэй болоод байна. Үүнд,

*Ажиллагаа явуулах, үйл ажиллагаа явуулах* - ажиллах

*Албан татвар хураах ажиллагаа эхлэх* - Албан татвар хурааж эхлэх

*Монголд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага* – Монголд ажиллаж байгаа байгууллага

*Шалгалтын дүнг танилцуулах ажиллагаа эхэллээ* – Шалгалтын дүнг танилцуулж эхэллээ гэх мэт.

г. Өшөө гэдэг орос үг монгол хэлний нэлээд олон үгийг харилцааны үүрэггүй болгож, хэрэглээнээс гаргаад байгаа бөгөөд энэ үгийн оронд тохирох монгол үгийг зөв сонгон хэрэглэж сурмаар байна.

Дээр дурдсанчлан, эх хэлний үнэлэмж буурч, үндэстний сэтгэлгээ эвдэрч харьжиж буйн жишээ маш олон буйн дотроос сүүлийн үед хамгийн ноцтой болж байгаа нь



“Монгол ураг төрлийн холбоог зааж,овог нэрийг . . .”(Бадамдорж.2001. х - 96)<sup>13</sup> ялгах ёсыг эвдэж буй жишээ байна. Монгол хэл, сэтгэлгээний ёсоор Батын Баатар, Дэлгэрийн Хишигт, Бадрахын Жаргал гэж харьяалуулан холбож хэлдэг, бичдэг атал англи зэрэг харь хэл, сэтгэлгээтнийг дуурайн, овог нэрээ Бат Баатар, Дэлгэр Хишигт, Бадрах Жаргал гэх мэтээр үл харьяалуулан, холбоогүй тасархай бичих юм уу Баатар Бат, Хишигт Дэлгэр, Жаргал Бадрах гэх мэтээр Европынхон шиг тонгоргон бичиж, будлиан тарьдаг болоод байна. Жон Смит гэдэг англи хүн овог нэрээ монголоор бичлээ гэхэд Смитийн Жон гэж хэзээ ч бичихгүй, бас Смит Жон ч гэдэггүй шиг Батын Баатар хэмээх монгол хүн овог нэрээ англи эхэд оруулахдаа Бат Баатар гэж бичих нь үндэстнийхээ сэтгэлгээ, үндэснийхээ хэлбичгийг үнэлэх үнэлэмжгүй болж буйн илрэл учраас энэ алдааг даруйхан засах хэрэгтэй. Ийм алдаа судалгааны бүтээлийн номзүйд ч ихээхэн гардгийг залруулж,монголоороо сэтгэж бичих нь зүйтэй байна.

## НОМЗҮЙ

1. Ц.Баатартогтох (2000), *Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал*, Дисс. Улаанбаатар.
2. Ц.Баатартогтох (2007), *Монгол хүний үнэлэмжийн байдал*, “Соёл судлаач багш нарын үндэсний Y семинарын материал”, Улаанбаатар.
3. Д.Бадамдорж (2001), *Монгол хэлний утгасудлал*, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар.
4. Ц. Базаррагчаа (1999), *Хэдэн үеэ бүрэлгэх хэлний гамшиг*, “МСС. ЭШБ. Улаанбаатар.
5. БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл. I дэвтэр (1941), Улаанбаатар.
6. В.В.Виноградов (1950), *О категории модальности и модальных словах в русском языке*, “Труды института русского языка”. М-Л.
7. Т.Дорждагва (2002), *Соёлын философи* (түүхэн товчоон) Улаанбаатар.
8. С.Дулам (2005), *Монгол хэл соёлыг минь мохоох гээд байна уу даа?*. “Монгол хэл бичиг.1.”
9. Ш.Лувсанвандан (2005), *Хэл, харьцаа, тэмдэг*, Улаанбаатар, 2005.
10. Ю.Мөнх-Амгалан (1997), *Орчин цагийн монгол хэлний баймжийн айн төвийн тогтолцоо*, МУИС. МСДС.ЭШБ.Улаанбаатар, №9 (126)
11. Л.Одонтуяа (2004), *Монгол зүйр цэцэн үгэнд, үнэлэмж илрэх онцлог*, Докторын (Ph.D.) зэрэг горилох нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар.
12. Ц.Шагдарсүрэн (2007), *Эх хэлээ эвдэхгүй юм сан . . .* Улаанбаатар.

## SUMMARY

The values of any people are expressed through their national cultural heritage and mentality. Mentality is a true expression of cultural values and is distinct to each nations. Research on values is therefore extremely valuable in appreciating the qualities and characteristics of any nation's mentality.

<sup>13)</sup> Д.Бадамдорж. *Монгол хэлний утга судлал*. Тэргүүн дэвтэр. УБ.2001